



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ  
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН 2015 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2016.01.05

Сүхбаатар



**“Иргэн таны төлөө”** уриалгыг аймгийн хэмжээнд бодлогын зорилт болгосонтой уялдуулж 2015 оныг Төрийн албаны салбар зөвлөлөөс **“Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүйг эрхэмлэх жил”** болгон зарлалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээ нь зарласан жилийнхээ зорилго, зорилтоо хэрэгжүүлэхэд чиглүүлэн ажиллалаа.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан **“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх үзүүлэлт”**-ийн дагуу дараах байдлаар тайлагнаж байна.

**Нэг. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө, стратегийг тодорхойлж, түүний хэрэгжилтийг зохион байгуулсан ажил үр дүн:**

Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлын хүрээнд Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн санхүүгийн дэмжлэгээр Унгар улсын **“IFUA HORVATH-PARTNERS”** стратеги төлөвлөлтийн мэргэжлийн олон улсын байгууллагын зөвлөх үйлчилгээний хүрээнд “Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газрын 2015-2018 оны стратеги төлөвлөгөө”-г зураглалын хамт боловсрууллаа.





**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



Аймгийн Засаг даргын Тамгын газрын стратеги зураглалын **“Мэргэшсэн чадварлаг төрийн байгууллага болох”** үндсэн зорилгын хүрээнд **“Хүний нөөцийн стратеги төлөвлөлт”**-ийн үйл явцыг тусгаж Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай уялдуулан жил бүрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөг тодотгон боловсруулж хэрэгжилтийг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажилласнаар бодлогын баримт бичгийн биелэлт 88.9 хувийн гүйцэтгэлтэй байна.

Төрийн албаны зөвлөлийн “Алсын хараа”, “Эрхэм зорилго”, “Эрхэмлэн дээдлэх зүйлс”, Стратегийн зарчмыг үйл ажиллагааныхаа удирдлага болгон энэхүү зорилго, зорилтуудыг салбар зөвлөлийн самбарт байнгын хэлбэрээр байршуулан сурталчилан ажиллаж байна.

Төрийн үйлчилгээг хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлагад нийцүүлж тэдгээрийн сэтгэл ханамж, үнэлэмжийг дээшлүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газрын “Алсын хараа”, “Эрхэм зорилго”-ыг шинэчлэн тодорхойлж аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдын албан тасалгаа бүрт байршуулан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна.

Стратегийн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангах ажлыг жил бүрийн үйл ажиллагааныхаа төлөвлөгөөндөө тусгаж, төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг хангах, төрийн албан хаагчдын ёс зүйн хариуцлагыг өндөржүүлж, цомхон, чадварлаг, үр дүнд чиглэсэн төрийн албыг бүрдүүлэх, төрийн албаны шинэтгэлийг орон нутагт хэрэгжүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн, нутгийн захиргааны байгууллагын хүний нөөцийн удирдлагын чадавхийг хөгжүүлэх, төрийн албаны ёс зүйн хэм хэмжээг хангуулахад мэргэшил, арга зүйн зөвлөгөө дэмжлэгээр ханган ажиллаж байна.

**Хоёр. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн:**

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь 5 бүлэг 13 арга хэмжээний хүрээнд 25 ажил үйлчилгээг төлөвлөн баталгаажуулж хэрэгжилтийг хангаж ажилласнаар төлөвлөгөөний гүйцэтгэл 93.9 хувьтай байна.

Мөн аймгийн хэмжээнд **“Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар ёс зүйг эрхэмлэх жил”** болгон зарлаж, 4 чиглэлийн 21 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүллээ. Салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой баримт бичгийн 8 хавтсыг бүрдүүлж, тогтоол, тэмдэглэл, албан бичиг, заавар журам, төрийн албан



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



хаагчийн сургалтын баримт материалыг ангилан цэгцэлж жил бүрийн эцэст архивлах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Салбар зөвлөлийн 2015 оны төлөвлөгөөний дагуу аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцэх асуудалд “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагаа, үр дүн”-гийн тухай танилцуулга хийх ажлыг тусган салбар зөвлөлийн дарга, гишүүдийн бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж оролцсон нь энэ оны төлөвлөгөөнд тусгагдсан онцлог ажлуудын нэг байлаа.

Тайлант онд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 26 тогтоол, 95 албан бичиг, 10 удаагийн хуралдааны хэлэлцэх асуудлын дараалал болон тэмдэглэл боловсруулан, баталгаажуулж холбогдох арга хэмжээг авч ажилласан.

2015 онд Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардалд 10.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган батлуулж, салбар зөвлөлөөс зохион байгуулах сургалт, сурталчилгааны зардалд 4000.0, бичиг хэргийн зардалд 480.0, томилолт, шатахууны зардалд 3220.0, салбар зөвлөлийн гишүүдийн урамшууллын зардалд 2200.0 мянган төгрөгийг төсвийн дагуу зарцуулж гүйцэтгэлийг тайлагнаж ажиллалаа.

**Гурав. Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэр, шийдвэрийн хэрэгжилт тооцсон байдал, хуралдааны тэмдэглэлийг албажуулсан байдал:**

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл нь тайлант онд 10 удаа хуралдаж, 31 асуудлыг хэлэлцэн төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх, Төрийн албаны тэргүүний ажилтнаар тодорхойлогдсон хүнийг хэлэлцэж уламжлах, салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлыг хянан шийдвэрлэх, өргөдөл гомдлыг магадлан шалгасан дүгнэлт, салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухай зэрэг асуудлыг тухай бүр нь хуралдаанаараа хэлэлцэж шийдвэрлэлээ.

№	Салбар зөвлөлийн хуралдаан	Хуралдаан болсон огноо	Хэлэлцсэн асуудлын тухай	Шийдвэрлэлт
1	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан	2015.02.03	1.Төрийн албаны салбар зөвлөлийн 2015 оны ажлын төлөвлөгөөний төсөл 2. Сайхан сумын Иргэн М.Энхтунгалаг,	1. Төлөвлөгөөний төслийн хэлэлцэж гишүүдийн санал болгосон ажил арга хэмжээг тусган төслийг батлалсан. 2. Сайхан сумын Иргэн М.Энхтунгалаг, О.Анхцэцэг нарын



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



	№01		<p>О.Анхцэцэг, Хүдэр сумын иргэн Ш.Урнаагийн өргөдлийн хэлэлцэх 3. Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулах тухай 4. 2014 оны “Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх” жил болгон зарласан жилийн ажлын дүнгийн тухай</p>	<p>өргөдлийг магадлан шалгах ажлын хэсгийг томилж явуулахаар болсон. Хүдэр сумын иргэн Ш.Урнаагийн өргөдлийн хариуг Хүдэр сумын ЗДТГ-т хүргүүлсэн 3. Орхонтуул сумын ЗДТГ-ын дарга Ш.Өнөрбаярыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар уламжилсан. 4. 2014 оны “Төрийн албан хаагчийн ажлын хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх” жил болгон зарласан жилийн ажлын дүнгийн тухай мэдээлэл өгсөн.</p>
2	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №02	2015.03.27	<p>1.Төрийн захиргааны албан хаагчид зэрэг дэв олгох тухай 2.Өргөдөл гомдлыг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай 3. Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулах тухай 4. 2015 оныг хэрхэн зарлах тухай</p>	<p>1. Нийт 98 хүний материалыг хянан хэлэлцэж 84 хүнд төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгуулахаар аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлсэн. 2. Сайхан сумын иргэн М.Энхтунгалагийн өргөдөл гомдлын дагуу Номгон тосгоны цэцэрлэгийн эрхлэгч Д.Баярхүүд сахилгын шийтгэл ногдуулах тухай саналыг хүргүүлэв.Носгон тосгоны ЭМТ-ийн эрхлэгч Н.Өлзиймаатай холбоотой О.Анхцэцэгт зөвлөмж хүргүүлэхээр тогтов 3. Хушаат сумын ахмад И.Цэдэн-Ишийг “Төрийн албаны тэргүүний ажилтан цол” тэмдгээр шагнуулахаар уламжилсан. 4. 2015 оны “Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүйг эрхэмлэх жил” болгон зарлахаар тогтов.</p>
3	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №03	2015.04.13	<p>1. Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөөцөөс нөхөх зарын дагуу бүртгүүлсэн иргэдийн тухай 2. Хүдэр, Жавхлант сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын</p>	<p>1. Нөөцөд бүртгэлтэй иргэдээс зарлагдсан ажлын байранд бүртгүүлсэн 2 иргэнийг нэр дэвшүүлэв. 2. Хүдэр сумын ЗДТГ-ын даргаар Ц. Гэрэлцогтыг, Жавхлант сумын ЗДТГ-ын даргаар хамгийн өндөр оноо авсан Ц.Рэгээдмааг тус тус нэр дэвшүүлэн томилуулахаар сумын Засаг дарга нарт нь уламжлахаар тогтов. 3.Сайхан сумын ЗДТГ-ын төрийн сангийн төлөөлөгч Үнэнбаттай холбоотой асуудлаар тус сумын</p>



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



			дүнгийн тухай 3.Сайхан сумын иргэн Д.Гарьдрагчаагийн өргөдлийн тухай	ИТХ-ын төлөөлөгч Д.Гарьдрагчаагийн өргөдөл гомдлыг Э.Оюунболд, Ч.Энхтуяа, М.Нарантуяа нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг газар дээр нь магадлан шалгахаар тогтов.
4	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №04	2015.04.28	1.Сүхбаатар аймгийн Төрийн албаны салбар зөвлөлтэй уулзалт, ярилцлага зохион байгуулах тухай 2 . Алтанбулаг сумын иргэн Болормаа, Ганболд нарын өргөдөл гомдлын тухай 3. Хүдэр сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын талаар ирүүлсэн саналын тухай	1.Сүхбаатар аймгийн ТАСЗ-ийн бүрэлдэхүүнийг хүлээн авч салбар зөвлөлийнхөө үйл ажиллагааг танилцуулах, харилцан ярилцлага зохион байгуулах ажлыг төлөвлөж хийхээр тогтов. 2..Алтанбулаг сумын иргэн Б.Болормаагийн ТАСЗ-д ирүүлсэн өргөдөл гомдолд дурьдсан асуудал нь нэгэнт шүүхийн шийдвэр гарсан байх тул Төрийн захиргааны албан хаагч нарт арга хэмжээ авах эрх зүйн үндэслэлгүй гэж үзсэн тухай албан бичгээр хариуг хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ. 3. Хүдэр сумын Засаг даргад хууль хэрэгжүүлэн ажиллах тухай албан тоот хүргүүлэхээр тогтов.
5	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №05	2015.06.16	1.Говьсүмбэр аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнтэй уулзалт зохион байгуулах тухай	1.Говьсүмбэр аймгийн Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнтэй уулзаж харилцан ярилцлага зохион байгуулж туршлага солилцлоо.
6	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №06	2015.07.06	1.Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухай мэдээлэл 2.Сайхан сумын иргэн Д.Гарьдрагчаагийн өргөдөл гомдлыг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай 3.Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн М.Нарантуяагийн өргөдлийн тухай 4.“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр	1. Төрийн албаны зөвлөлөөс аймаг нийслэлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаар танилцуулсан мэдээллийг салбар зөвлөлийн нийт гишүүдэд танилцуулж, цаашид анхаарах нийтлэг асуудлуудыг танилцуулав. 2. Сайхан сумын ЗДТГ-ын даргад Р.Үнэнбатын гаргасан алдаа зөрчлийг дурьдаад сахилгын шийтгэл ногдуулах арга хэмжээ авах тухай албан тоот хүргүүлэх, мөн Сумдын ИТХ-ын ажлын албанд энэхүү алдаа дутагдал гарч байгаа тухай сануулсан зөвлөмж хүргүүлэхээр тогтов. 3. Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын дүнгийн дагуу хамгийн өндөр оноо





**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



			шагнуулах тухай	авч томилогдох ёстой хүнийг хуулийн дагуу шийдвэрлэхээр тогтов. 4.Төрийн албаны тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулахаар тодорхойлсон Түнхэл тосгоны соёлын төвийн эрхлэгч Ц.Байгалмаагийн холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Төрийн албаны зөвлөлд уламжлахаар тогтов.
7	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №07	2015.09.28	1.Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөөцөөс нөхөх зарын тухай мэдээлэл 2.Сайхан сумын иргэн М.Мөнхбаясгалан -Сүхбаатар сумын иргэн О.Нарантуяа 3.“Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулах тухай	1.Төрийн захиргааны 34 албан тушаалын сул орон тооны зарыг Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Нөөцөөс нөхөх зар 10 дугаар сарын 05-ны өдрийг хүртэл бүртгэгдэхээр тухай мэдээлэл хийв. 2. Сайхан сумын Соёлын ордны захирлын албан тушаалын сонгон шалгаруулалтын зарыг ирүүлэх тухай Төрийн албаны салбар зөвлөлийн албан бичиг хүргүүлэхээр тогтов. - Сүхбаатар сумын иргэн О.Нарантуяагийн Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн мэргэжилтэн Ц.Отгонтуяатай холбоотой зүй бус харилцааны асуудлыг Тамгын газрын “Ёс зүйн хороо”-д хандан албан бичиг хүргүүлж, дүгнэлтийг харгалзан арга хэмжээ авахаар тогтов. 4. Төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүнээс болзол хангаж байгаа салбар зөвлөлийн дарга Ө.Сувдаа, нарийн бичгийн дарга Д.Ган-Отгон нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар Төрийн албаны зөвлөлд уламжилсан.
8	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №08	2015.10.06	1.Төрийн жинхэнэ албаны сул орон тоог нөөцөөс нөхсөн тухай 2. “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлэг зохион байгуулах тухай 3.”Залуу төрийн албан хаагчдын уулзалт, зөвлөгөөн”-ийг зохион байгуулж	1. Нөөцөд бүртгэлтэй иргэдээс зарлагдсан ажлын байранд бүртгүүлсэн 2 иргэнийг нэр дэвшүүлэв. 2. “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлгийг 2015 оны 10 дугаар сарын 07-ны өдрийн 18.00 цагт “Миний Монгол” орон нутгийн телевизээр зохион байгуулахаар тогтов. 3. Төрийн залуу албан хаагчдын



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



			оролцох тухай	уулзалт зөвлөгөөн"-д төрийн албаны салбар зөвлөлийн бүрэлдэхүүн оролцохоор тогтов.
9	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №09	2015.12.23	1.Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлын тухай 2. “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулах тухай 3.Төрийн албаны салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухай мэдээлэл 4. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны зардлын тухай	1. Мандал сумын иргэн Ц.Батцэрэн, Зүүнбүрэн сумын иргэн Б.Уянга, Г.Уртнасан, Сүхбаатар сумын иргэн Ж.Сэлэнгэ нарын өргөдлийг хянан шалгах ажлын хэсгийг томилов. 2. АЗДТГ-ын мэргэжилтэн Д.Нансалмаа, УБХ-ийн мэргэжилтэн Д.Цогзолмаа, Сум дундын иргэний хэргийн шүүхийн ерөнхий шүүгч Л.Энхтайван нарыг “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнуулахаар уламжилсан. 3. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны тухай, батлагдсан төсвийн зардлын тухай мэдээлэл хийв.
10	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаан №10	2015.12.30	1. Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлыг шалгасан ажлын хэсгийн дүгнэлтийн тухай	1. Мандал сумын иргэн Ц.Батцэрэнгийн аймгийн НДХ-ийн даргын шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байгаа шийдвэрийг үндэслэлтэй гэж үзлээ. 2. Зүүнбүрэн сумын иргэн иргэн Б.Уянга, Г.Уртнасан нарыг Зүүнбүрэн сумын Соёлын төвд сонгон шалгаруулалтын дагуу авч ажиллуулахыг даалгав. 3. Сүхбаатар сумын иргэн Ж.Сэлэнгээг ажлаас халсан аймгийн ХХААГ-ын даргын шийдвэрийг үндэслэлтэй гэж үзэж тогтоол гаргахаар шийдвэрлэв.

Салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудал, гарсан шийдвэрийн талаарх мэдээ, мэдээллийг аймгийн албан ёсны цахим хуудсанд байрлах “Төрийн албаны салбар зөвлөл” гэсэн талбарт байршуулан мэдээлэх ажлыг тогтмолжууллаа.

Орон нутгийн төрийн захиргааны байгууллагад олон жил идэвх, зүтгэл үр бүтээлтэй ажиллаж байгаа 8 төрийн албан хаагч Төрийн албаны зөвлөлийн даргын тушаалаар “Төрийн албаны тэргүүний ажилтан” цол тэмдгээр шагнагдсан. Мөн төрийн албан хаагчдын ажлын үр дүнгийн үнэлгээ, идэвх санаачлагыг харгалзан 79 төрийн албан хаагчийг аймгийн Засаг даргын “Жуух бичиг”-ээр урамшууллаа.



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



**Дөрөв. Орон нутаг, салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартыг хэрэгжүүлэх болон бүрэн эрхт хамаарах асуудлаар арга зүйн зөвлөмж өгсөн байдал, үр дүн:**

Салбар зөвлөлийн жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөний уламжлалт арга хэмжээ болох зөвлөн туслах ажил үйлчилгээг аймгийн Засаг даргын 2013 оны А/449 дүгээр захирамжаар баталсан “Зөвлөн туслах ажлын хэсэг ажиллуулах” тухай журмын дагуу Жавхлант, Мандал, Баянгол сумдад төрийн захиргаа, хүний нөөцийн чиглэлээр зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж, мэргэшил арга зүйн зөвлөмж, дэмжлэгээр хангаж ажилласан. Мөн 2015 онд улсын хэмжээнд зохион байгуулагдсан “Архивын улсын үзлэг”-т бэлтгэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагуудад Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсгийг томилон ажиллуулж, үзлэгийн удирдамжинд тусгасан төрийн байгууллагын зохион байгуулалт, төрийн албаны стандартын хэрэгжилтийн талаар зөвлөгөө дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч ажилласан.

Сүхбаатар, Говьсүмбэр, Завхан аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүд Сэлэнгэ аймагт ажиллаж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаатай танилцан харилцан ярилцаж, туршлага солилцох арга хэмжээг зохион байгууллаа.

**Тав. Орон нутаг, салбарын хэмжээнд хууль, журам, заавар, төрийн албаны стандартын хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байдал, үр дүн:**

Төрийн албаны салбар зөвлөлөөс зарласан **“Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүйг эрхэмлэх жил”** -ийн хүрээнд нутгийн захиргааны байгууллагуудаас зохион байгуулсан ажил арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж үр дүнг тооцож ажиллалаа. Төрийн албаны зөвлөлөөс зарласан жилийн хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор сумдын Засаг даргын Тамгын газраас санаачлан зохион байгуулсан шинэлэг ажил арга хэмжээнээс тоймловол:

**Баянгол сум:** Төрийн албан хаагчдын ажлын байрны тодорхойлолтыг шинэчлэн **“ашиг сонирхолын зөрчилгүй авлигаас ангид байх, ёс зүйг эрхэмлэн ажиллах”** талаар тусган, албан хаагчдын ажлын цаг ашиглалт, төрийн байгууллага, албан





**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол, хариутай, хугацаатай бичгийн шийдвэрлэлт, харилцааны соёл, үйлчилгээний шуурхай байдлыг хангах үүднээс **“Хариуцлагын карт”** хөтлөн үнэлж дүгнэсэн байна.

**Ерөө сүм:** Төрийн албан хаагчдын ажил үйлчилгээний талаар иргэдийн саналыг асуумжийн хуудсаар авч дүгнэн “Харилцаа, ёс зүйтэй төрийн албан хаагч”, “Иргэдийн сэтгэлд хүрсэн үйлчилгээг үзүүлсэн албан хаагч”-ийг шалгаруулан урамшуулж ажилласан байна.

**Жавхлант сүм:** Сумын төрийн захиргааны албан хаагчидтай “Ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах тухай гэрээ” байгуулан үр дүнг тооцож ажилласан байна. мөн эрхэмлэх есөн зүйлээр хэлэлзүүлэн хийж, уриалга гарган ажилласан. “төрийн албан хаагчийн ёс зүй үйлчилгээний чанарт нөлөөлөх нь” сэдэвт илтгэлийн уралдаан зарлан урамшуулсан байна.

**Орхонтуул сүм:** **“Явуулын иргэний танхим”** сэдэвт ажлыг санаачлан зохион байгуулж иргэдэд мэдээ, мэдээллийг хүргэн хүрч үйлчилсэн нь иргэдийн сэтгэлд нийцсэн арга хэмжээ болсон байна.

**Сайхан сүм:** **“Хамтдаа хөгжье”, “Мэдлэгийг эрхэмлэе”** сарын аяны хүрээнд төрийн албан хаагч бүр ажлын үнэмлэх, энгэрийн тэмдэг, нэрийн хуудастай болсон. Төрийн албан хаагчдын ёс зүйн тулгамдсан асуудал түүнийг сайжруулах нь” сэдэвт уран илтгэлийн уралдааныг аймгийн хэмжээнд зарлаж тэргүүлсэн албан хаагчдад “Өргөмжлөл” мөнгөн шагналаар урамшуулсан байна.

Сайхан сумын Засаг даргын Тамгын газраас орон нутгийн төрийн албан хаагчдын албан хэрэгцээнд зориулан гарын авлага, тараах материалыг өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан хэвлэж, гаргасан байна.

Дэлхийн зөн Олон улсын байгууллагыг дэмжлэгтэйгээр “Оюуны хөгжлийн институт”-тэй хамтран **“Хувь хүний хөгжил”** 4 хоногийн цогц сургалтыг зохион байгуулж нийт 75 хүнийг хамруулж “Сертификат” олгосон байна.

**Мандал сүм:** Хөдөлмөрийн тухай хуулийн үзэл баримтлал сэдвээр Удирдлагын академийн багш, доктор Ц.Уранцэцэгийн сургалтыг зохион байгуулж 105 төрийн албан хаагчийг хамруулсан байна. Мандал сумын орон нутгийн телевизээр тасаг, алба бүр хуваарийн дагуу шууд нэвтрүүлэгт оролцож үйл ажиллагаагаа сурталчлахын зэрэгцээгээр, иргэдийн санал, асуултанд хариулт өгч ажилласан байна.



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



**Алтанбулаг сум**: Сумын Засаг даргын Тамгын газар “Хувь хүний хөгжлийн институт”-тэй хамтран **“Хувь хүний хөгжил болон гэр бүлийн харилцаа”** сэдэвт сургалтыг зохион байгуулж 67 төрийн албан хаагч хамрагдсан байна.

**Зургаа. Төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулсан ажил, үр дүн, Төрийн албан хаагчийг давтан сургах хэрэгцээг судлан хэрэгжүүлсэн ажил, үр дүн:**

Аймгийн хэмжээний “Төрийн албан хаагчийн мэдлэг чадвар” хөтөлбөрийн хүрээнд төрийн албан хаагчийн сургалтын хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай сургалтыг ажлын байран дээр нь зохион байгуулах замаар орон нутгийн төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх, давтан сургах ажил арга хэмжээг нутгийн захиргааны бүх шатны байгууллагуудад зохион байгуулахад бодлого зохицуулалт, арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх зорилгоор богино хугацааны зорилтот сургалтыг “Төрийн албаны эрх зүй”, “Бүтээмж”, “Өөрчлөлтийн менежмент”, “Дөрвөн талт түншлэл”, “Төрийн албаны ёс зүй”, “Хувь хүний гүйцэтгэлийн менежмент”, “Төслийн менежмент”, “Төрийн албан хаагчдын үйлчилгээний маркетинг” зэрэг сэдвүүдээр зохион байгуулж давхардсан тоогоор нийт 780 гаруй албан хаагчид хамруулаа.

**“Орон нутгийн хөгжил-төрийн захиргааны шинэчлэл”** уулзалт зөвлөгөөнийг 2015 оны 04 дүгээр сарын 02-04-ний өдрүүдэд Төрийн албаны зөвлөл, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг, Орон нутгийн тогтвортой хөгжлийн институттэй хамтран зохион байгуулж Баяхонгор, Өвөрхангай, Сэлэнгэ, Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн албан хаагчдыг хамруулж, Төрийн албаны зөвлөлийн орон тооны гишүүн Т.Хадхүү, Орон нутгийн тогтвортой хөгжлийн институтийн захирал Н.Бурмаа, Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага төслийн захирал Ханс Заделман нар урилгаар оролцож илтгэл тавилаа.

ХБНГУ-ын Конрад Аденаурын сангийн санхүүжилтээр зохион байгуулж буй **“Иргэдийн оролцоо”** сургалт 2015 оны 10 дугаар сарын 21-ний өдөр Сэлэнгэ аймагт зохион байгууллаа. Сургалтанд аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлагийн мэргэжилтнүүд болон Сүхбаатар сумын 8 багийн иргэдийн



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



төлөөлөл, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын сургуулиудын монгол хэлний багш нар оролцлоо.

Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Эрдэс баялаг түүхий эдийн иж бүрэн санаачлага хөтөлбөрөөс Сэлэнгэ аймагт хэрэгжүүлж буй “Орон нутгийн цогц хөгжил” төслийн хүрээнд төрийн албан хаагчдыг чадавхжуулах, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилгоор 8 удаагийн шаталсан сургалтыг зохион байгуулсан.

Нийт сумдаас авсан хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хэрэгжилтийг тайлагнах судалгааны дүнгээр төрийн албан хаагчдыг мэргэшүүлж, чадавхжуулах зорилгоор мэргэжил дээшлүүлэх сургалтанд 483, мэргэшүүлэх сургалтанд 828, богино хугацааны зорилтот сургалтанд 2880, ажлын байран дахь сургалтанд 6713 албан хаагчийг хамруулж мэдлэг ур чадварыг дээшлүүлсэн байна.

**Долоо. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах асуудлаар зохион байгуулсан ажил үр дүн:**

Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2009 онд аймгийн Засаг даргын захирамжаар шинэчлэн баталж мөрдөн ажиллаж байна. Энэхүү хөтөлбөр нь төрийн албаны үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулахад төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа, эрүүл мэндийг хамгаалан хангахтай холбоотой ажил, арга хэмжээг нутгийн захиргааны бүх шатны байгууллагууд өөрсдийн нөөц боломжинд тулгуурлан төлөвлөж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт хэрэгжилтийг тайлагнах судалгааны дүнгээс харахад сумдад ажиллаж буй нийт 4708 төрийн албан хаагчийн 12,5 хувь нь нийтийн, 14.9 хувь нь хувийн, 68.4 хувь нь амины орон сууцанд, 4,0 хувь нь гэрт амьдарч байна. Дээрх албан хаагчдын 4.8 хувь буюу 229 хүн орон сууцны зээлэнд хамрагдсан дүнтэй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 405 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-ын дагуу 2015 онд аймгийн хэмжээнд төрийн албанаас чөлөөлөгдөж тэтгэвэр тогтоолгосон 26 төрийн албан хаагчид 663509.7, байгууллагын даргын шийдвэрээр 103 хүнд 124108.3



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



мянган төгрөгийн буцалтгүй тусламж, Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.4.2 дахь заалтын дагуу 13 хүнд 2500,0 мянган төгрөгийн тусламж дэмжлэг үзүүлсэн байна.

Хөвсгөл аймагт болсон Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Хөвсгөл, Төв зэрэг 7 аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтнуудын дунд зохион байгуулагдсан 5 төрөлт нөхөрсөг уулзалт тэмцээнд багаараа амжилттай оролцож сагсан бөмбөгийн төрөлд эмэгтэй баг алтан медаль, ширээний теннисний тэмцээнд эмэгтэй алтан медаль, шатар эрэгтэй хүрэл медаль хүртсэн амжилт үзүүллээ.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын шийдвэрээр орон тооны бус “Спортын зөвлөл” байгуулагдаж жилийн ажлын төлөвлөгөө гарган сар бүр нэг хэлтсийн нэрэмжит спортын “Цамхаг”, аяга өрөлтын тэмцээн, “Чанга шивнээ”, “Шагайн наадгай”, Гар бөмбөг, хөгжилтэй хөл бөмбөгийн зэрэг тэмцээн наадмыг зохион байгуулсан.

Мөн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтсийн санаачилгаар “Бүтээлч үйлс” явган аяллыг зохион байгуулж Сүхбаатар сумын нутаг дэвсгэрт байрлах “Оргидог булаг” түүхийн дурсгалт газрын орчин тойрныг цэвэрлэж, булгийн эхийг хамгаалах ажлыг хамт олноороо хийж гүйцэтгэлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх 22 хэлтэс, агентлагийн нийт 389 суурин, зөөврийн 97 компьютер, хэвлэгч машин 119, scanner 21, проектор 11, мөн 17 сумын Засаг даргын Тамгын газарт 232 суурин, зөөврийн 46 компьютер, хэвлэгч 176, scanner 24, проектор 16, хувилагч машин 23 тус тус хэрэглэгдэж байгаа нь төрийн албан хаагчдын өдөр тутмын хэвийн үйл ажиллагаа явуулах нөхцөл боломжоор бүрэн хангагдсан байна.

**Найм. Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа, ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн:**

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах ажлыг 4 удаа орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сонин, аймгийн [www.selenge.gov.mn](http://www.selenge.gov.mn) болон Төрийн албаны зөвлөлийн [www.csc.gov.mn](http://www.csc.gov.mn) цахим хуудсаар нийтэд зарлан зохион байгууллаа. Удирдах ажилтны сонгон шалгаруулалтыг тухай бүр Төрийн албаны зөвлөлд хүсэлт гарган цахим хэлбэрээр явууллаа.

Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалын Жавхлант, Хүдэр сумын Засаг даргын Тамгын газрын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



шалгаруулалтанп 3 хүн оролцож, хамгийн өндөр оноо авсан 2 хүнийг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэж холбогдох албан тушаалатанд нэр дэвшүүлснээр уг албан тушаалд томилогдон ажиллаж байна.

Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалын Шаамар, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэг, Баруунбүрэн, Түнхэл тосгоны сургуулийн захирлын албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах зарыг Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсанд байршуулан зарлаж аймгийн Боловсролын газартай хамтран 5 удаа гарган цахим хэлбэрээр зохион байгуулахад мэргэшил арга зүйн зөвлөгөө, дэмжлэг үзүүлж зохион байгууллаа.

Нийт төрийн жинхэнэ болон үйлчилгээний удирдах албан тушаалын зарлагдсан 6 ажлын байранд 15 хүн өрсөлдөж хамгийн өндөр авсан 6 хүнийг холбогдох газруудаас нийтийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг баримтыг авч аймгийн Засаг даргын захирамжаар хамгийн өндөр оноо авсан 6 хүн Шаамар, Зүүнбүрэн, Баруунбүрэн, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч, Баруунбүрэн, Түнхэл тосгоны сургуулийн захирлын албан тушаалд албан тушаалд томилогдон ажиллаж байна.

**Ес. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний мэргэшлийн шалгалт, нэр дэвшүүлсэн ажиллагаа ил тод, нээлттэй байдлыг хангасан байдал, үр дүн:**

Төрийн жинхэнэ албан тушаалын давхардсан тоогоор 46 сул ажлын байрыг Төрийн албаны зөвлөлийн болон аймгийн албан ёсны цахим хуудсаар ил тод нээлттэй байдлаар зарлан Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 99 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц бүрдүүлэх журам”-ын дагуу нөөцөөс нөхөх арга хэмжээг 2 удаа 2015 оны 4,10 дугаар сард зарын дагуу зохион байгуулан 4 ажлын байрны тавигдах шаардлагыг хангасан 5 хүн бүртгүүлснийг Төрийн албаны салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн 4 хүнийг тухайн ажлын байранд нь томилуулахаар нэр дэвшүүлэх ажлыг зохион байгууллаа. 2015 онд Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг 2 удаа цахим хэлбэрээр зохион байгуулан нийт давхардсан тоогоор 34 байгууллагын 46 албан тушаалд 406 иргэн бүртгүүлж **113** хүн Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 114, 209 дугаар тогтоолоор төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдийн нөөцийн жагсаалтанд бүртгэгдлээ. Тухайн өрсөлдсөн ажлын байрандаа хамгийн өндөр оноо авч нэр дэвшсэн 31 иргэн дэс түшмэлийн ангиллын, 24 иргэн туслах түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд томилогдон ажиллаж байна.



**Төрийн албаны зөвлөлийн  
Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



**Арав. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний болон удирдах ажилтны нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн:**

Төрийн жинхэнэ албан тушаалын удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтанд хамрагдаж нөөцөд бүртгэгдсэн 3 хүн байна. Нөөцөд бүртгэлтэй иргэдээс төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдсон хүн одоогоор байхгүй байна.

**Арван нэг. Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сан бүрдүүлж, түүгээр үйлчилсэн байдал, үр дүн:**

Аймгийн хэмжээнд төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцэж, төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтанд бүртгэлтэй 216 иргэн байна. Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-ийг баримтлан өрсөлдсөн албан тушаалдаа хамгийн өндөр оноо авч томилогдсон 87 иргэн, орон нутгийн харъяаллын дагуу нөөцөд бүртгэгдэн бусад аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагын төрийн жинхэнэ албан тушаалд томилогдон холбогдох баримт материалыг нь хүргүүлсэн 8 иргэн, нөөцөөс нөхөн томилсон 4 иргэнд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн сангийн мэдээллээр үйлчилсэн дүнтэй байна.

Төрийн жинхэнэ албан тушаалын нөөцийн санд бүртгэлтэй байгаа иргэдийн хүсэлтээр төрийн жинхэнэ албан тушаалд томилогдох нийт 26 хүнд төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэдийн нөөцөд бүртгэлтэй байгаа тухай Төрийн албаны зөвлөлийн тогтоолыг үндэслэн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн тодорхойлолт гаргаж өгсөн байна.

**Төрийн жинхэнэ албан хаагчийн нөөцийн сангийн судалгаа:**

№	Шалгалт болсон огноо	Сул ажлын байрны тоо	Тэнцсэн хүний тоо	1-ээр гарсан хүний тоо	Нөөцөөс нөхсөн	Шилжүүлсэн	Нөөцөд бүртгэлтэй хүний тоо
1	2014.03.11	50	61	15	1	0	45
2	2014.06.27	52	23	11	2	0	10
3	2014.12.15.	50	76	24	0	0	52
	2014 оны нийт	152	160	50	3	0	107





**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



1	2015.05.15	27	51	15	1	1	34
2	2015.11.09	36	63	22	1	2	38
	2015 оны нийт	63	114	37	2	3	72
	<b>Нийт дүн</b>	<b>215</b>	<b>274</b>	<b>87</b>	<b>5</b>	<b>3</b>	<b>179</b>

**Арван хоёр. Төсвийн шүүд захирагч, менежер, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах, дүгнэх ажлыг мэргэшлийн удирдлагаар хангаж, үр дүнг тооцсон байдал:**

Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 134 дүгээр тогтоолоор батлагдсан төсвийн шууд захирагчийн, менежерийн, төрийн жинхэнэ албан хаагчийн үр дүнгийн гэрээ байгуулах заавар, төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журмын дагуу гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, үнэлэх явцад мэргэшил, арга зүйн удирдлагаар хангаж, түүний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа.

**Төсвийн шүүд захирагчийн үр дүнгийн гэрээ, түүний хэрэгжилт:**

Нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны нэгдсэн зөвлөгөөнийг 2015 оны 02 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулан нутгийн захиргааны байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааг үнэлж, дүгнэн аймгийн салбарын тэргүүний ажилтнуудаа тодруулж, 2015 оны бодлого зорилтоо тодорхойлон аймгийн Засаг даргаас сумдын Засаг дарга нартай бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ болон төсвийн шууд захирагч нартай үр дүнгийн гэрээг байгууллаа. Төсвийн шууд захирагч нарын үр дүнгийн гэрээний хавсралт байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний загварыг танилцуулж, төлөвлөгөөг боловсруулах арга зүйн сургалтыг сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар, хэлтэс агентлагийн дарга нарыг хамруулан зохион байгуулж, мэргэшил, арга зүйн зөвлөгөө өгч хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллалаа. Мөн аймгийн боловсрол, соёлын салбарт 2015 онд баримталж ажиллах бодлого чиглэлээ тодорхойлох, удирдах ажилтнуудыг чадавхжуулах зорилгоор **“Сүргүүл, цэцэрлэгийг үр дүнтэй удирдах нь”** сэдэвт сургалт, боловсрол, соёлын салбарын байгууллагуудын удирдах ажилтнуудтай гэрээ байгуулах арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээний хүрээнд ерөнхий



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



боловсролын сургуулийн 36 захирал, 39 эрхлэгч, 5 соёлын байгууллагуудын дарга, эрхлэгч, сумын Засаг даргатай гурвалсан гэрээг байгуулах ажлыг нэгдсэн удирдлагаар хангалаа.

Төсвийн шууд захирагч нарын 2015 оны үр дүнгийн гэрээний биелэлтэнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулсан үнэлгээний дүнгийн нэгтгэсэн судалгааг дараах байдлаар харуулбал:

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ АГЕНТЛАГИЙН  
ДАРГА НАРЫН 2015 ОНЫ ҮР ДҮНГИЙН ГЭРЭЭНИЙ  
ҮНЭЛГЭЭНИЙ НЭГТГЭЛ**

№	Байгууллагын нэр	Дарга нарын нэрс	Нийт арга хэмжээний		Тусгай арга хэмжээний		Манлайл-лын зорилтын		Нийт оноо	Үнэлгээ
			Тоо	Оноо	Тоо	Оноо	Тоо	Оноо		
1	ᠶᠡᠳᠡᠭᠡᠭᠡᠢ ᠲᠦᠢ ᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ	Д.Энхсайхан	31	29	5	40	5	26	95.0	A
2	ᠲᠡᠪᠠᠭᠲᠤ	Т.Баатар	42	30	3	36.2	3	27	93.2	A
3	ᠪᠡᠷᠳᠡᠨᠭᠡᠮᠡᠭ	Б.Эрдэнэчимэг	18	27	4	36.5	3	28	91.5	A
4	Худалдан авах ажиллагааны алба	С.Хүрэлбаатар	15	25.3	3	34.5	2	23	82.8	B
5	ᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ ᠠᠭᠤᠨ	Б.Батзориг	35	26.2	5	29.8	3	27	83	B
6	ᠬᠡᠳᠠᠪᠠᠭᠠᠬᠤ	Х.Даваахүү	41	27	8	35	3	28	90	A
7	ᠵᠡᠮᠣᠩᠬᠤ	Ж.Отгонхүү	38	25	9	37	5	25	87	B
8	Авто замын үндэсний төвийн Сэлэнгэ аймаг дахь салбар	Ч.Жамбалнямбуу	15	27.6	4	31.5	2	25	84.1	B
9	ᠮᠡᠷᠭᠡᠭᠡᠮᠠᠭ	М.Рэгзэдмаа	34	28	8	35	5	27	90	A
10	ᠰᠤᠮᠠᠭᠤᠭᠢᠨ	Ш.Отгонбаяр	22	26	8	36	25	27	89	B
11	ᠰᠤᠪᠠᠭᠤᠨ	С.Баасансугар	15	26.6	5	26	3	39	91.6	A
12	Санхүүгийн хяналт, аудитын алба	Б.Дарихжав	18	25	4	32	3	27	84	B
13	ᠶᠡᠳᠡᠭᠡᠭᠡᠢ	Ж.Од	17	27	3	35	4	26	88	B
14	ᠳᠡᠵᠠᠭᠳᠣᠭᠴᠣᠰᠤ	Д.Загдгочоо	57	25	9	36	5	29	90	A
15	Биеийн тамир, спортын газар	Б.Баттулга	35	27.5	5	31.5	5	27	86	B
16	Хөдөлмөрийн хэлтэс	Л.Зоригтбаатар	51	27	5	36	4	28	91	A





**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



албанаас гэрээний биелэлтэнд хяналт шинжилгээ хийж үр дүнгийн гэрээний үнэлгээнд санал дүгнэлт өгдөг ажлыг хэвшүүлсэн.

**Төсвийн шүүд захирагч, менежер, төрийн албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ:**

Сум, хэлтэс албадын үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын дагуу нутгийн захиргааны байгууллагуудын 2014 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийж, үнэлгээний үр дүнгээр тэргүүн, дэд, гутгаар байр эзэлсэн сум, сумын Засаг дарга нар, алба, хэлтэс, газрууд түүний дарга нар, баг, багийн Засаг дарга нарыг 21780.5 мянган төгрөг, тэргүүний хамт олон, салбарын тэргүүний ажилтнуудыг 2331.0 мянган төгрөгөөр шагнаж урамшууллаа.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга буюу төсвийн шууд захирагчийн 2015 оны үр дүнгийн гэрээгээр нийт ажил үйлчилгээ 157, тусгай захиалгат ажил үйлчилгээ 22, манлайллын зорилтыг хэрэгжүүлэх талаар 8, нийт 187 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилласныг аймгийн Засаг дарга буюу Төсвийн ерөнхийлөн захирагчаас гэрээний биелэлтийг **95.2** хувьтай **“маш сайн”** гэж үнэллээ.

Сумдын Засаг даргын Тамгын газрын төрийн захиргааны нийт 398 албан хаагчдын 2015 оны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээгээр **“А”** буюу **“маш сайн”** үнэлгээтэй 142, **“В”** буюу **“сайн”** үнэлгээтэй 218, **“С”** буюу **“хангалттай”** үнэлгээтэй 41, **“D”** буюу **“дутагдалтай”** **5**, **“Е”** буюу **“хангалтгүй”** үнэлгээтэй 2 буюу дундаж үзүүлэлтийг тооцвол **82.2** буюу **В** үнэлгээтэй байна.

2014 оны төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээний биелэлт, үйл ажиллагаа мэргэшлийн түвшний үнэлгээгээр хангалттай үнэлгээ авсан ахлах, дэс, туслах түшмэлийн ангиллын 84 төрийн захиргааны албан хаагчид аймгийн Засаг даргын 2015 оны А/114 тоот захирамжаар төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэвийг шинээр болон ахиулан олголоо.

**Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв олгосон байдлыг сүүлийн 10 жилийн байдлаар үзүүлбэл:**

<b>Төрийн захиргааны албан тушаалын ангилал</b>	<b>2006 он</b>	<b>2007 он</b>	<b>2008 он</b>	<b>2009 он</b>	<b>2010 он</b>	<b>2011 он</b>	<b>2012 он</b>	<b>2013 он</b>	<b>2014 он</b>	<b>2015 он</b>



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



<b>Ахлах тшмэл</b>	<b>4</b>	<b>3</b>	<b>7</b>	<b>3</b>	<b>6</b>	<b>6</b>	<b>3</b>	<b>2</b>	<b>10</b>	<b>5</b>
<b>Дэс түшмэл</b>	<b>17</b>	<b>15</b>	<b>23</b>	<b>25</b>	<b>42</b>	<b>43</b>	<b>62</b>	<b>48</b>	<b>60</b>	<b>39</b>
<b>Туслах түшмэл</b>	<b>36</b>	<b>30</b>	<b>21</b>	<b>11</b>	<b>22</b>	<b>20</b>	<b>25</b>	<b>37</b>	<b>27</b>	<b>40</b>
<b>Нийт дүн</b>	<b>57</b>	<b>48</b>	<b>51</b>	<b>39</b>	<b>70</b>	<b>69</b>	<b>90</b>	<b>88</b>	<b>97</b>	<b>84</b>

Төрийн албанд олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан төрийн албан хаагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Монгол Улсын гавьяат-1, “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 4, “Алтан гадас одон”-оор 28, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-аар 21 төрийн албан хаагч шагнагдсан байна.

Монгол Улс тунхагласны баярын өдрийг тохиолдуулан аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг төрийн захиргааны байгууллагуудын төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргүүлэх ёслолын ажиллагааг аймгийн Засаг даргын Тамгын газрын хуралдааны их танхимд зохион байгуулан 11 байгууллагын 29 төрийн захиргааны албан хаагч тангараг өргөж, төрийн жинхэнэ албан хаагч боллоо.

**Арван гурав. Ёс зүйн хороог арга зүйн удирдлагаар хангаж Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах асуудлаар зөвлөгөө өгч, ажилласан байдал, үр дүн:**

Аймгийн хэмжээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, сумдын Засаг даргын Тамгын газарт 18, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудад 18, нийт 36 ёс зүйн хороо томилогдон ажиллаж байна.

2015 оны байдлаар ёс зүйн хороодын мэдээлснээр төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой 3 зөрчил, дутагдал гарсаныг хэлэлцэн дүгнэлт гаргаж, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр сахилгын шийтгэл ногдуулсан байна.

**Арван дөрөв.Өргөдөл, гомдол, маргаан, ёс зүйн зөрчлийн шийдвэрлэлт, үр дүн, түүний мэдээг хагас бүтэн жилээр ирүүлсэн байдал:**

Аймгийн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд Төрийн албатай холбоотой асуудлаар 22 төрийн албан хаагчийн өргөдөл, гомдол ирснийг бүртгэн холбогдох хууль, журмын дагуу тухай бүр нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг томилон дүгнэлт гаргуулж, салбар зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэн хуулийн хугацаанд нь шийдвэрлэж ажиллалаа.



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



**Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хандсан өргөдөл гомдлын**  
**шийдвэрлэлт:**

<b>№</b>	<b>Өргөдөл гаргагчийн нэр</b>	<b>Өргөдлийн утга</b>	<b>Шалгасан ажлын хэсэг</b>	<b>Шийдвэрлэсэн байдал</b>	<b>Тайлбар</b>
1	Хүдэр сумын иргэн Ш.Урнаа	Ажил орохыг хүссэн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Хүдэр сумын ЗДТГ-ын даргад ТАЗСЗ-ийн 2015.02.04-ны өдрийн 09 дугаар албан бичиг	Төрийн жинхэнэ албанд анх орон иргэний нөөцөд бүртгэлтэй байгаа тухай
2	Ерөө сумын ЗДТГ-ын мэргэжилтэн М.Урангоо	Цалингийн ангилал зэрэглэл буруу олгож байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Ерөө сумын ЗДТГ-ын даргад ТАЗСЗ-ийн 2015.02.04-ны өдрийн 10 дугаар албан бичгээр албан тушаалынх нь цалинг олгохыг даалгасан	Цалин олгогдсон.
3	Сүхбаатар сумын иргэн Б.Маралцэц	Ажил орохыг хүссэн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргад 2015.03.16-ны өдрийн 22 дугаар албан бичгээр нэр дэвшүүлсэн.	Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын тушаалаар томилогдсон.
4	Сайхан сумын иргэн М.Энхтунгалаг	Номгон тосгоны цэцэрлэгийн эрхлэгчийн үйл ажиллагааны тухай	Ажлын хэсэг: Ч.Даваадорж Д.Энхтуяа Ч.Алтантуяа Ц.Сонинбаяр	ТАЗСЗ-ийн 2014.04.14-ний өдрийн 34 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	Эрхлэгч Д.Баярхүүд сахилгын шийтгэл ногдуулсан.
5	Түнхэл тосгоны цэцэрлэгийн ажилтнууд	Эрхлэгч Т.Лхагважавын тухай	Ажлын хэсэг: Ж.Батсайхан Э.Оюунболд Т.Доржхуяг	ТАЗСЗ-ийн 2014.04.14-ний өдрийн 35 дугаар албан бичгээр хүргүүлсэн.	Төрийн албан хаасан хугацааг зохих хууль журмын дагуу тодорхойлсон
6	Сүхбаатар сумын иргэн Д.Туул	Нөөцөөс нөхөгдөх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Сүхбаатар сумын ЗДТГ-ын дарга Д.Энхзаяад 2015.04.13-ны 31 дугаар албан бичгээр нэр дэвшүүлсэн.	Сумын байгаль хамгаалагчаар томилогдсон.
7	Сайхан сумын иргэн У.Аминдаваа	Нөөцөөс нөхөгдөх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Сайхан сумын ЗДТГ-ын дарга Ч.Тунгалагт 2015.04.13-ны 30 дугаар албан бичгээр нэр дэвшүүлсэн.	Сайхан сумын ЗДТГ-ын дарга татгалзсан хариу ирүүлсэн.
8	Сүхбаатар сумын иргэн Т.Уянга	Нөөцөөс нөхөгдөх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Аймгийн ХМХА-ны дарга Н.Үнэнбаатарт 2015.04.13-ны 29	Бүтэц орон тооны өөрчлөлт хийсэн тул





**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



				дугаар албан бичгээр нэр дэвшүүлсэн.	томилоогүй.
9	Сайхан сумын иргэн С.Гэрэлбаяр	Нөөцөөс нөхөгдөх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Мандал сумын ЗДТГ-ын дарга Д.Байгалмаад ТАЗСЗ-ийн 2015.04.15-ны өдрийн 36 дугаар албан бичгээр нэр дэвшүүлсэн.	Хэрх тосгоны Захирагчийн албаны мэргэжилтнээр томилогдсон.
10	Хүдэр сумын иргэн Ц.Гэрэлцогт	Ажилд томилохгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Хүдэр сумын Засаг дарга Б.Наранцэцэгт 2015.05.07-ны өдрийн 40 дугаар албан бичгээр хууль хэрэгжүүлэн ажиллах тухай даалгасан	Хүдэр сумын Засаг даргын 2015 оны Б/08 дугаар захирамжаар сумын ЗДТГ-ын даргаар томилогдсон.
11	Аймгийн ЗДТГ-ын мэргэжилтэн М.Нарантуяа	Ажилд томилохгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Аймгийн Зааг даргад ТАЗСЗ-ийн 2015.07.06-ны өдрийн 53 дугаар албан бичгээр санал зөвшилцөхөөр хүргүүлсэн.	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын даргын 2015 оны Б/63 тушаалаар СТСХ-ийн даргаар томилогдсон.
12	Сайхан сумын иргэн Д.Гарьдрагчаа	Сайхан сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Р.Үнэнбатын тухай	Ажлын хэсэг: Э.Оюунболд Ч.Энхтуяа М.Нарантуяа	Сайхан сумын ЗДТГ-ын дарга Ч.Тунгалагт ТАЗСЗ-ийн 2015,07.06-ны өдрийн 55 дугаар албан бичгээр арга хэмжээ авч ажиллахыг даалгасан.	Сайхан сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Р.Үнэнбатад сахилгын шийтгэл ногдуулж хариуг иргэн Гарьдрагчаад хүргүүлсэн.
13	Жавхлант сумын иргэн Э.Мөнхнасан	Жавхлант сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Ц.Батчимэгийн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Жавхлант сумын ЗДТГ-ын дарга Ц.Рэгээдмаад ТАЗСЗ-ийн 2015.10.02-ны өдрийн 73 дугаар албан бичгээр арга хэмжээ авч ажиллахыг даалгасан	Жавхлант сумын ЗДТГ-ын мэргэжилтэн Ц.Батчимэгт сахилгын шийтгэл ногдуулсан.
14	Сүхбаатар сумын иргэн О.Нарантуяа	Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын НХХ-ийн мэргэжилтэн Ц.Отгонтуяагийн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Аймгийн ЗДТГ-ын ёс зүйн хорооны дарга Ч.Даваадоржид судалж дүнэлт гаргахыг даалгасан ТАЗСЗ-ийн 2015.10.02-ны өдрийн 74 дугаар албан бичмг	АЗДТГ-ын даргын шийдвэрээр Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын НХХ-ийн мэргэжилтэн Ц.Отгонтуяад



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



				хүргүүлсэн.	сахилгын шийтгэл ногдуулсан.
15	Сайхан сумын иргэн М.Мөнхбаясгал ан	Сайхан сумын Соёлын ордны даргын сонгон шалгаруулалтын тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Сайхан сумын Засаг дарга С.Энхтайванд ТАЗСЗ-ийн 2015.10.02-ны 75 дугаар албан бичгээр сонгон шалгаруулалтын зар ирүүлэх тухай даалгасан.	Аймгийн БСГ-ын мэргэжилтэнд сонгон шалгаруулалтын зар ирүүлэх тухай зөвлөсөн.
16	Мандал сумын иргэн М.Ууганбаатар	Нөөцөөс нөхөгдөх тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Баянгол сумын ЗДТГ-ын дарга Б.Болор-Эрдэнэд ТАЗСЗ-ийн 2015.10.06-ны өдрийн 77 дугаар албан бичгээр нэр дэвшүүлсэн.	Иргэн М.Ууганбаатар өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзсан байна.
17	Хүдэр сумын иргэн Д.Насанжаргал	Ажилд эгүүлэн авахгүй байгаа тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Хүдэр сумын ЗДТГ-ын дарга Ц.Гэрэлцогтод ТАЗСЗ-ийн 2015.10.19-ны өдрийн 78 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	Тамгын газрын үйлчилгээний ажилчин Д.Насанжаргалыг ажилд нь үргэлжлүүлэн ажиллуулсан.
18	Алтанбулаг сумын иргэн Ц.Болормаа	Аймгийн МХГ-ын байцаагчийн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Аймгийн МХГ-ын дарга Д.Энхсайханд ТАЗСЗ-ийн 2015.11.11-ны өдрийн 80 дугаар албан бичгээр дүгнэлт гаргаж өгөхийг даалгасан.	Төрийн хяналт шалгалтын тухай хуулинд заасанчлан боломжгүй гэсэн хариу ирүүлсэн.
19	Эрдэнэт хотын иргэн Л.Тодгэрэл	Бугант тосгоны соёлын төвийн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Аймгийн БСГ-ын дарга Д.Загдгочоод ТАЗСЗ-ийн 2015.12.23-ны 88 дугаар албан бичиг хүргүүлсэн	Бугант тосгоны соёлын төвийн үйл ажиллагааны талаар судалж хариу өгөхийг даалгасан.
20	Зүүнбүрэн сумын иргэн С.Эрдэнэчимэг	Зүүнбүрэн сумын ЗДТГ-ын мэргэжилтэн С.Цэлмэгийн тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Зүүнбүрэн сумын ЗДТГ-ын дарга Д.Гантулгад ТАЗСЗ-ийн 2015.12.30-ны өдрийн 97 дугаар албан бичгээр хариу хүргүүлсэн.	Зүүнбүрэн сумын ЗДТГ-ын даргын тушаалаар сахилгын шийтгэл ногдуулсан
21	Зүүнбүрэн сумын иргэн Б.Уянга,	Сонгон шалгаруулалтын тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Зүүнбүрэн сумын Соёлын төвийн эрхлэгч	Соёлын төвийн бүжгийн багш, орон нутаг



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



	Г.Уртнасан нар			Д.Лхамгарьдад ТАЗСЗ-ийн 2015.12.30-ны өдрийн 96 дугаар албан бичгээр хариуг хүргүүлсэн	судлах танхимын ажилтнаар авч ажиллуулахаар болсон.
22	Сүхбаатар сумын иргэн Ж.Сэлэнгэ	Ажлаас үндэслэлгүй халсан тухай	ТАЗСЗ-ийн хуралдаанаар хэлэлцсэн	Ажлын хэсгийн дүгнэлтийг хэлэлцээд ТАЗСЗ-ийн 2015.12.30-ны өдрийн 27 дугаар тогтоолоор хариуг хүргүүлсэн.	Аймгийн ХХААГ-ын даргын 2015 оны 48 дугаар тушаалыг үндэслэлтэй байна гэж үзсэн.

**Арван тав. Салбар зөвлөлийн үйл ажиллагааны нээлттэй байдал, үйл ажиллагааг сурталчилсан байдал, үр дүн:**

Төрийн албаны хууль тогтоомжийн болон хэрэгжилтийн талаарх төрийн байгууллагаас хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээний талаарх мэдээлэл авах боломжоор хангах үүднээс аймгийн **“Selenge.gov.mn”** цахим хуудсанд цаг үеийн шуурхай мэдээллүүдийг байршуулж, аймгийн Засаг даргын Тамгын газрын сар тутмын **“Өргөн Сэлэнгэ”** мэдээллийн сонин гарган үйлчилж байна. Сонины дугаар бүрт төрийн үйлчилгээний үйл ажиллагааны талаар иргэдээс мэдээлэл авах утас, хаяг, хариу мэдээллийг тогтмол нийтэлдэг болсон. Энэхүү мэдээллийн хуудсыг 17 сум, 6 тосгонд тухай бүр хуваарилан хүргүүлж иргэдэд түргэн шуурхай хүргэх ажлыг зохион байгуулж хэвшлээ.

Орон нутгийн “Миний Монгол” телевизийн “Иргэдээ сонсьё” шууд нэвтрүүлэгт 2015 оны 4, 10 дугаар сард Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга гишүүд оролцож, салбар зөвлөлийн үйл ажиллагааны болон төрийн албаны мэргэшлийн шалгалтын талаар танилцуулж иргэдийн сонирхсон асуултанд хариуллаа.

Мөн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн даргын “Авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээг бид урагшлуулж чадсан” гарчигтай ярилцлагыг үндэсний өдөр тутмын “Зууны мэдээ” сонины ярилцах цаг буланд нийтлүүлж салбар зөвлөлийн ажил үйлчилгээний талаар олон нийтэд мэдээллээ.

Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн самбарт Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, Салбар зөвлөлийн шийдвэр, цаг үеийн мэдээ, мэдээлэл, төрийн албан хаагчдын тоо бүртгэлийн талаар болон хийж хэрэгжүүлж буй ажил арга хэмжээг самбарт байршуулж сурталчилах ажлыг тогмолжуулаад байна. Мөн төвийн “Зууны



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



мэдээ” сонин, Монголын үндэсний болон TV-9 телевиз орон нутгийн, “Сэлэнгийн мэдээ”, “Шинэ гэгээ” сонин “Миний Монгол” кабелийн телевиз, аймгийн Засаг даргын тамгын газраас эрхлэн гаргадаг “Өргөн Сэлэнгэ” сар тутмын мэдээллийн сонин зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс явуулж буй цаг үеийн ажил арга хэмжээний талаар ярилцлага өгөх, нийтлэх зэргээр сурталчлах ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Төрийн албаны зөвлөлийн шийдвэрээр аймаг, нийслэлийн салбар зөвлөлүүдээс 2014 оны ажлын үр дүнгээр дэд байр эзэлж “Өргөмжлөл” хүртсэнийг аймгийн цахим хуудас, салбар зөвлөлийн самбарт байршуулж мэдээллээ.

**Арван зургаа. Төрийн албан хаагчийн тайлан мэдээ ирүүлсэн байдал:**

Төрийн албаны салбар зөвлөлөөс аймгийн хэмжээний төр, төсвийн байгууллагын нийт төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг суурилагдсан программын дагуу хийх заавар зөвлөмжийн талаар холбогдох ажилтнуудад сургалт зохион байгуулж, тоо бүртгэл явуулах хуваарь гарган ажилласнаар төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь чанартай сайн хийж гүйцэтгэн аймгийн хэмжээнд 5801 /бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн 2014 оны дүнгээр/ төрийн албан хаагчийн бүртгэл бүхий нэгдсэн мэдээллийн сан бүрдүүллээ. Аймагт үйл ажиллагаа явуулж буй аймгийн Гаалийн газрын 122, Цагдаагийн газрын 256 төрийн албан хаагчийн мэдээлэл харьяалах дээд шатны байгууллагадаа нэгтгэгдсэн болно.

Мэдээллийн санг ашиглан төрийн албан хаагчдад шаардлагатай төрийн албан хаагчийн биеийн байцаалт, бусад холбогдох шаардлагатай тоо баримт, мэдээллээр хангаж ажиллаж байна.

Төрийн албаны салбар зөвлөлийн самбарын мэдээллийн хэсэгт аймгийн хэмжээний төрийн албан хаагчдын тоон мэдээллийг төрийн албаны ангилал, нас, боловсрол, хүйсийн байдлаар графикаар дүрслэн байршуулж мэдээллээ.

Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн программ хангамжийн талаар төр, төсвийн нийт байгууллагуудын дотоод ажил, хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтнуудыг мэргэшил арга зүйн удирдлагаар хангаж ажилласнаар жил бүр батлагдсан хуваарийн дагуу байгууллагынхаа төрийн албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг хугацаанд нь гүйцэтгэж хэвшлээ.

**Арван долоо. Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх асуудлаар хэрэгжүүлсэн шинэлэг ажил, үр дүн:**



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



Салбар зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, олон нийтэд сурталчлах чиглэлээр 2015 онд дараах ажил, арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа. Үүнд:

- Төрийн албаны мэргэшлийн шалгалтыг **УЛСЫН ХЭМЖЭЭНД АНХ УДАА** шалгалтын үйл явцыг гаднаас хянах боломж бүрдүүлж, **теле камер нэвтрүүлсэн, төрийн албаны төв зөвлөлд шүүд дамжуулах ажлыг эхлүүлж, хөндлөнгийн ажиглагчдыг ажиллуулсан** зэрэг шинэлэг ажил арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр иргэдийн мэргэшлийн шалгалтанд хандах хандлага, итгэл үнэмшил, сэтгэл ханамж дээшилсэн үр дүнтэй байна.
- Төрийн албаны салбар зөвлөлөөс зарласан жилийн жилийн хүрээнд **“Төрийн залуу албан хаагчдын үүзлалт, зөвлөгөөн”**-ийг “Сэлэнгэ сайхан нутаг” ТББ-тай хамтран 2015 оны 10 дугаар сарын 09-ны өдөр зохион байгуулж аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс, агентлаг, сумдын Засаг даргын Тамгын газрын болон төр, төсвийн байгууллагын 35 хүртэлх насны 300 гаруй залуу албан хаагчдыг оролцуулж шинэ, шинэлэг сэтгэлгээтэй эрч хүчтэй, эрмэлзлэлтэй ажиллахыг уриаллаа.
- **“Дурсамж, сургамж, зөвлөмж”** сэдэвт 3 үеийн төрийн албан хаагчдын уулзалт ярилцлагыг аймгийн хэмжээнд анх удаа зохион байгуулж аймгийн үе үеийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг урилгаар оролцуулан тэдний ололт амжилт, сургамж, зөвлөмжийг хойч үедээ үлдээх, төрийн залгамж чанарыг хадгалахад чиглэсэн түүхэн ач холбогдолтой арга хэмжээ болсон. Энэхүү уулзалтанд 17 сум 6 тосгоны ахмад, дунд залуу үеийн төлөөлөл бүхий нийт 450 гаруй албан хаагчид оролцлоо.
- Цахим засаглалыг орон нутагт хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Засгийн газар, Төрийн албаны зөвлөлийн шийдвэрийг нутгийн захиргааны байгууллагуудад хүргүүлэх, хэрэгжилтийг шуурхай хангах зорилгоор аймгийн Засаг даргын Тамгын газраас нийт сум, зарим хэлтэс, агентлагтаа **“Байгууллагын удирдлагын цогц систем”**-ийг нэвтрүүллээ.







**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



зөвхөн төрийн албаны мэргэшлийн шалгалтыг зохион байгуулдаг, цахим шалгалтыг сайшаасан саналууд дийлэнх хувийг эзэлж байна.

Сум, тосгоны төрийн байгууллага, төрийн захиргааны албан хаагчдын, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний хэлтэс агентлагуудын ажил үйлчилгээний талаар иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч судалгааны үр дүнг нийтэд танилцуулж, санал асуулгын үр дүнгийн мөрөөр авах арга хэмжээний төлөвлөн хэрэгжилтийг ханган ажилладаг нь жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг **“Ээлтэй үйлчилгээ-Иргэн танд”** арга хэмжээний нэг гол ажил юм.

**Арван ес. Салбар зөвлөлийн хагас, бүтэн жилийн тайлан ирүүлсэн байдал:**

2015 оны эхний хагас жилийн тайланг Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн загварын дагуу болосвруулсан салбар зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хагас жилийн биелэлтээр тайлагнаж, хавсралт Төрийн албаны зөвлөлийн зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь хүргүүлж ажилласан.

Мөн Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015 оны үйл ажиллагааны тайланг Төрийн албаны зөвлөлийн 2014 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 126 дугаар тогтоолоор батлагдсан **“Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажил дүгнэх 20 үзүүлэлт”**-ийн дагуу боловсруулж Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүргүүлээ.

**Хорь. Төрийн албаны зөвлөлөөс өгсөн хугацаатай үүрэг даалгаврын биелэлт:**

2015 онд Төрийн албаны зөвлөлөөс ирсэн тогтоол, зөвлөмж, заавар журмын мөрөөр хийсэн ажлын талаарх судалгааг дараах байдлаар гаргалаа.

**Төрийн албаны зөвлөлөөс 2015 онд ирсэн  
албан бичгийн шийдвэрлэлт:**

№	Огноо	Дугаар	Хаанаас ирсэн	Бичгийн утга	Хэрэгжилт
<b>Хугацаатай тайлан мэдээний тухай</b>					
1	2015.01.20	91	Төрийн албаны зөвлөл	Тайлан ирүүлэх тухай	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015.04.03-ны өдрийн 26 дугаар албан бичгээр аудитын шалгалтын дүгнэлт, зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тайланг боловсруулж хүргүүлэв
2	2015.	92	Төрийн албаны	Ажлын	Төрийн албаны зөвлөлийн салбар



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



	01.20		зөвлөл	байрны судалгаа ирүүлэх тухай	зөвлөлийн 2015.02.02-ны өдрийн 06 дугаар албан бичгээр иргэд бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны судалгааг хүргүүлэв
3	2015.03.20	432	Төрийн албаны зөвлөл	Тайлбар авах тухай	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2015.03.23-ны өдрийн 24 дугаар албан бичгээр бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлангийн зөрүүтэй байгаа тайлбарыг хавсралт судалгааны хамт хүргүүлсэн.
4	2015.05.01	686	Төрийн албаны зөвлөл	Баримт бичиг ирүүлэх тухай	Хүдэр сумын ЗДТГ-ын даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын тухай баримт бичгийг тайлбарын хамт ТАЗСЗ-ийн 2015 оны 41 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
5	2015.04.27	662	Төрийн албаны зөвлөл	Сургалтанд оролцуулах тухай	Төсөв санхүүгийн боломжгүй талаар холбогдох ажилтанд мэдээлэл хүргүүлсэн.
6	2015.08.26	1190	Төрийн албаны зөвлөл	Мэдээлэл ирүүлэх тухай	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга нарын судалгааг боловсруулж ТАЗСЗ-ийн 2015.09.08-ны өдрийн 62 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
7	2015.09.14	1266	Төрийн албаны зөвлөлийн ажлын алба	Судалгаа ирүүлэх тухай	Төрийн жинхэнэ албанд анх орох иргэдийн нөөцөөс нэр дэвшүүлсэн тухай судалгааг ТАЗСЗ-ийн 2015.09.16-ны өдрийн 67 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
8	2015.11.11	1498	Төрийн албаны зөвлөл	Судалгаа ирүүлэх тухай	Төрийн жинхэнэ болон үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулалтын сүүлийн 10 жилийн дүн мэдээг боловсруулж цахим шуудангаар хүргүүлэв.
9	2015.12.03	1605	Төрийн албаны зөвлөл	Тайлан судалгаа, тэмдгийн дардас ирүүлэх тухай	Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн дарга, гишүүдийн судалгаа, салбар зөвлөлийн тэмдэгний дардасыг маягтын дагуу гаргаж ТАЗСЗ-ийн 2015.12.11-ний өдрийн 86 дугаар албан бичгээр хүргүүлсэн.
10	2015.12.03	1600	Төрийн албаны зөвлөл	Судалгаа ирүүлэх тухай	Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, нөөцийн сангийн



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



					судалгаа, иргэд бүртгүүлэхгүй байгаа ажлын байрны судалгааг шалгалтын үйлчилгээний зардлын хэмжээний саналыг маягтын дагуу боловсруулж хүргүүлэв.
11	2015.12.04	1608	Төрийн албаны зөвлөл	Бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан ирүүлэх тухай	2015 оны бүрэлдэхүүн хөдөлгөөний тайланг Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн системийн программыг дагуу шивж дуусган Төрийн албаны зөвлөлд хугацаанд нь хүлээлгэн өгөв.
<b>Тогтоол, заавар, зөвлөмжийн талаар:</b>					
1	2015.01.16	57	Төрийн албаны зөвлөл	Тогтоол хүргүүлэх тухай	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт баталсан тухай тогтоолыг ТАЗСЗ-ийн 2015.01.30-ны өдрийн 04 дугаар албан бичгээр холбогдох хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-т хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажилласан.
2	2015.02.05	176	Төрийн албаны зөвлөл	Албан бичгийн шуурхай байдлыг хангах тухай	2015 онд Төрийн албаны зөвлөлөөс ирүүлсэн хугацаатай тайлан мэдээ ирүүлэх тухай нийт 9 албан бичгийн хариуг хугацаанд нь албан бичгээр болон цахим шуудангаар холбогдох албан тушаалтанд хүргүүлж ажилласан.
3	2015.02.24	273	Төрийн албаны зөвлөл	Салбар зөвлөлүүдийн 2014 оны ажлыг дүгнэсэн тухай	Төрийн албаны зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 16-ны өдрийн 32 дугаар тогтоолоор 2014 оны ажлаараа тэргүүлсэн тухай тогтоолыг аймгийн ЗДТГ-ын болон салбар зөвлөлийн самбарт байршуулан сурталчлав.
4	2015.05.29	851	Төрийн албаны зөвлөл	Тогтоол хүргүүлэх тухай	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт баталсан тухай тогтоолыг ТАЗСЗ-ийн 2015.06.08-ны өдрийн 46 дугаар албан бичгээр холбогдох хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-т хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.
5	2015.06.05	872	Төрийн албаны зөвлөл	Тогтоол, зөвлөмж хүргүүлэх тухай	Төрийн үйлчилгээний удирдах албан тушаалд томилогдох сонгон шалгаруулалтын журмын нэмэлт өөрчлөлт, зөвлөмжийн талаар аймгийн Боловсрол, соёлын газарт зөвлөж хамтран ажиллаж байна.



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



6	2015. 12.03	1599	Төрийн албаны зөвлөл	Тогтоол хүргүүлэх тухай	Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцийн жагсаалт баталсан тухай тогтоолыг ТАЗСЗ-ийн 2015.12.08-ны өдрийн 84 дугаар албан бичгээр холбогдох хэлтэс, агентлаг, сумдын ЗДТГ-т хүргүүлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллаж байна.
---	----------------	------	----------------------	-------------------------	--

Тайлант онд Төрийн албаны зөвлөлөөс судалгаа, тайлбар ирүүлэх тухай хугацаатай 11, салбар зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тогтоол, заавар, зөвлөмж 6 ирснийг бүртгэн холбогдох арга хэмжээг авч хугацаанд нь тайлагнах ажлыг зохион байгууллаа.

**ДҮГНЭЛТ:**

Төрийн албатай холбоотой хууль тогтоомж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг үйл ажиллагааныхаа удирдлага болгон тайлант оныхоо зорилго, зорилтын хэрэгжилтийг хангах, орон нутгийн хүний нөөцийн чадавхийг хөгжүүлэх, стандартын удирдлагаар ханган мэргэшил арга зүй, бодлогын дэмжлэг үзүүлэх, үр дүнд суурилсан хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог нэвтрүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн 2015 оны ажлын үр дүнг холбогдох дээд шатны байгууллагаас үнэлж, дараах шагнал урамшууллыг хүртээсэн нь аймгийн төрийн ажил үйлчилгээнд ахиц дэвшил гарсан байна гэж үзэж байна.

Монгол Улсын хууль, тогтоомж, төрийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг орон нутагтаа амжилттай хэрэгжүүлж, засаглалын болон нийгэм, эдийн засгийн үзүүлэлтээ ахиулсан амжилт бүтээлийг төр засгаас үнэлж Сэлэнгэ аймгийг **“2014 оны Шилдэг аймаг”**-аар шалгаруулан **“Соёрхол”** хүртээсэн.

өрийн үйлчилгээг ил тод, нээлттэй, шуурхай шударга болгох, чанарыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2008 оны 265 дугаар тогтоолоор төрийн байгууллагад Чанарын удирдлагын тогтолцоо олон улсын ISO 9001:2008



**Төрийн албаны зөвлөлийн**  
**Сэлэнгэ аймаг дахь салбар зөвлөл**



стандартыг хэрэгжүүлэх тухай шийдвэрлэсний дагуу аймгийн Засаг даргын Тамгын газарт чанарын удирдлагын тогтолцооны олон улсын стандартыг 2012 оны 3-р сараас эхлэн нэвтрүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлсэн, тасралтгүй сайжруулалтыг бий болгосон, хэрэглэгчдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлсэн, төрийн албан хаагчдыг чадавхжуулсан зэрэг олон үр дүн гарч байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар нь чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх ажлыг Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгтэй хамтран хэрэгжүүлж, 2015 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр Монгол Улсын Засгийн газрын тохируулагч агентлаг Стандартчилал хэмжилзүйн газраас **Чанарын удирдлагын тогтолцоо MNS ISO 9001:2010 / ISO 9001:2008** стандартыг хэрэгжүүлсэн тухай баталгаажуулалтын гэрчилгээгээ гардан авсан.

Аймгийн хэмжээнд зохион байгуулсан авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, авлигын эсрэг хэрэгжүүлсэн ажил арга хэмжээний үр дүнг Авлигатай тэмцэх газраас үнэлж, **“Шударга ёсны төлөө 2015”** болзолт уралдааны **“Авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл, зориг, эрмэлзлэлтэй удирдагч”** шагналыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Ө.Сувдаа хүртсэн.

**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН**  
**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛ**